УУЛ УУРХАЙН ЗУРАГ ТӨСЛИЙН "ЦАРИГ РЕСУРС" ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ИНЖЕНЕР  
БАЯЖУУЛАГЧ ИНЖЕНЕР  
ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСАГЧ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН



Б.БУЯНХИШИГ

П.НАСАНЖАРГАЛ

Ч.ДОРЖГОТОВ

Ж.НОМИН-ЭРДЭНЭ

О.ЦОЛМОНТУЯА



АШИГТ МАЛТМАЛ,  
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар Т/110

Улаанбаатар хот

Техник, эдийн засгийн үндэслэл  
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Т/22-07-14 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Төв аймгийн Заамар сумын нутагт орших "Ирмүүн босго" ХХК-ийн MV-019638 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бумбат-6 талбайд орших Шинээгийн ам (хш-02-с хш-14), Жалга-3 (хш-02-с хш-8) алтны шороон ордуудыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол 2-ыг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник, эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

4. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

5. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-019638 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бумбат-6 талбайд орших Шинээгийн ам (хш-02-с хш-14), Жалга-3 (хш-02-с хш-8) алтны шороон ордуудыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол 2-ыг хуулсан дискийг Уул уурхай, судалгааны хэлтэст хүлээлгэн өгөхийг "Ирмүүн босго" ХХК-д даалгасугай.

УУЛ УУРХАЙ, СУДАЛГААНЫ ХЭЛТСИЙН  
ДАРГА  С.ЭНХБОЛД



5371 834



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДҮГНЭЛТ

2022 оны 06 дугаар сарын 10.

№ 7/22-07-14.

Улаанбаатар хот

Төв аймгийн Заамар сумын нутагт  
MV-019638 тоот ашиглалтын  
тусгай зөвшөөрөлтэй Бумбат-6  
талбайд орших "Шинээгийн ам" (хш-  
02-с хш-14), "Жалга-3" (хш-02-с хш-8)  
алтны шороон ордуудыг ил аргаар  
ашиглах техник-эдийн засгийн  
үндэслэлийн тодотгол 2-ыг  
хэлэлцсэн тухай

"Ирмүүн босго" ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн "Цариг ресурс" ХХК боловсруулсан Төв аймгийн Заамар сумын нутагт Бумбат-6 талбайд орших "Шинээгийн ам" (хш-02-с хш-14), "Жалга-3" (хш-02-с хш-8) алтны шороон ордуудыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 2-т Монгол улсын зөвлөх инженер Л.Жаргалсайхан зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер Г.Тамир, Ж.Амгалан нар шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-2-ыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Техник-эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 2 нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074 дүгээр тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

2. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 2 нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

3. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 2 нь Төслийн эдийн засгийн гол үзүүлэлтүүд, Ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Ил уурхайн үндсэн хэмжээсүүд, үйлдвэрлэлийн нөөц, Олборлолт, Уурхайн угаан баяжуулалтын хэсэг, Хүний нөөц, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, Төслийн эдийн засаг зэрэг 10 бүлэг, Дүгнэлт, Ашигласан материал бүхий 168 хуудас тайлбар бичиг, 19 хавсралт зургаас бүрдэж байна.

4. Бумбат-6 талбайд орших "Шинээгийн ам" (хш-02-с хш-14), "Жалга-3" (хш-02-с хш-8) алтны шороон ордуудын MV-019638 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн

хурлын ХХ-04-11 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан ҮГА-ны даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн н-39 дүгээр тушаалаар “Шинээгийн ам” (хш-02-с хш-14) ордод боломжтой С зэрэглэлийн 86.53 мян.м<sup>3</sup> элс, 143.23 кг буюу химийн цэврээр 121.87 кг алт, “Жалга-3” (хш-02-с хш-8) ордод бодитой В зэрэглэлийн 11.68 мян.м<sup>3</sup> элс, 9.63 кг буюу химийн цэврээр 8.8 кг алт, боломжтой С зэрэглэлийн 0.38 мян.м<sup>3</sup> элс, 0.2 кг буюу химийн цэврээр 0.18 кг алт, нийтдээ талбайн хэмжээнд В+С зэрэглэлээр 98.58 мян.м<sup>3</sup> элсний нөөц, 153.06 кг буюу химийн цэврээр 130.85 кг алтны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

5. Төсөлд ил уурхайг хаягдалгүй олборлох бөгөөд, бохирдол 32.0% буюу 31.56 мян.м<sup>3</sup> байхаар тооцож геологийн бодитой В болон боломжтой С зэрэглэлийн нөөцийг магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн тооцсоноор нийт 130.14 мян.м<sup>3</sup> элс байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 3,266.23 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийхээр тооцжээ. Жилд 105.0 мян.м<sup>3</sup> элс олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 2 жилийн хугацаанд ашиглах, 3 дахь жилд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн байна.

6. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, эдийн засгийн үр ашиг зэргийг харгалзан үзэж ил аргаар авто тээвэртэй, гадаад дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

7. Ил уурхайд CAT-D8 маркийн бульдозер 2 ширхэг, Hyundai 850 маркийн экскаватор 2 ширхэг, Hyundai 520 маркийн экскаватор 1 ширхэг, HOWO-371 маркийн автосамосвал 5 ширхэг, SDLG953 маркийн утгуурт ачигч 1 ширхэг, 80СБ скруббер 2 ширхэг гэсэн үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөжээ.

8. Угаан баяжуулах хэсгийн баяжуулах технологийг захиалагч талаас өгсөн техникийн даалгавар болон Геологийн төв лаборатори “ТӨҮГ-ын Технологи туршилтын лабораторид хийлгэсэн туршилтын үр дүнд үндэслэн урьдчилсан байдлаар сонгосон байна. Угаан баяжуулах хэсгийн хүчин чадал 105.0 мян.м<sup>3</sup>/жил байна.

9. Ордын элсийг гравитацийн аргаар баяжуулахаар төлөвлөжээ. Үүний үр дүнд 0.25%-ийн гарцтай, 92.6%-ийн металл авалттай баяжмал гарган авч болохыг тогтоосон байна. Анхдагч элсний дундаж агуулгийг 1.176 гр/м<sup>3</sup>-ээр тооцоонд авч ашигласан байна.

10. Бумбат-6 талбайд орших “Шинээгийн ам” (хш-02-с хш-14), “Жалга-3” (хш-02-с хш-8) алтны шороон ордууд нь ТЭХС-д холбогдсон ба уурхайн цахилгаан ачаалал 276.94 кВт бөгөөд хэрэглэгчдийг уурхайгаас баруун хойд талд 10 км зайд байрлах ДСЦТС-110 кВ-ын шугамнаас салбарласан 35 кВ-ын Баянголын дэд станцаас 6 кВ-ын агаарын шугам татан, 0.4 кВт-ын хүчдэлтэй 630 кВа-ын суурилагдсан хүчин чадалтай хаалттай дэд станц угсарч цахилгаан эрчим хүчээр хангахаар тусгажээ. Тус уурхайн унд-ахуй болон технологийн усны хэрэгцээнд орд ашиглалтын хугацаанд 200.44 мян.м<sup>3</sup> ус шаардлагатай бөгөөд үүнээс ажилчдын унд ахуйн хэрэгцээнд 1.25 мян.м<sup>3</sup> ус, зам усалгаанд 2.25 мян.м<sup>3</sup> ус, ногоон байгууламжийн усалгаанд 24.46 мян.м<sup>3</sup> ус, угаан баяжуулах хэсэгт нэмэлтээр 172.48 мян.м<sup>3</sup> ус ашиглахаар тооцжээ. Угаан баяжуулах хэсэгт ашигласан усны 70 хувийг эргэлтийн усаар ашиглах бөгөөд нэмэлтээр ашиглах цэвэр усыг тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдөж гаргасан 2 ширхэг гүний худаг болон 2 ширхэг үүсмэл нуураас хангахаар тусгажээ.

11. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 1,449.50 сая төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 24.8 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 913.64 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 175.69 сая төгрөг, дүйцүүлэн хамгаалах зардалд 50.0 сая

төгрөг, төслийн хаалтын зардалд 216.35 сая төгрөг, хаалтын дараах мониторингийн зардалд 69.02 сая төгрөгийг тус тус зарцуулахаар тусгажээ.

12. Уг төслийг хэрэгжүүлсэнээр 112 хүний ажлын байр хадгалагдаж үлдэх ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 2,243 мянган төгрөг байхаар байна.

13. Бумбат-6 талбайд орших “Шинээгийн ам” (хш-02-с хш-14), “Жалга-3” (хш-02-с хш-8) алтны шороон ордуудыг ашиглах ил уурхайн төсөл хэрэгжүүлэхэд нийт 5,345.26 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс барилга байгууламжийн хөрөнгө оруулалт 157.15 сая төгрөг, машин механизм, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 4,740.00 сая төгрөг, тавилга эд хогшилд 33.70 сая төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 70.18 сая төгрөг, биет бус хөрөнгө оруулалт 300.00 сая төгрөг, капитал ажлын зардал 44.24 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардал ашиглалтын хугацаанд 1,693.69 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

14. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 12,876.44 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 20,931.92 сая төгрөгийн борлуулалт хийж, 8,035.48 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 6,876.61 сая төгрөгийн цэвэр ашигтай, 8,570.30 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 3,363.76 сая төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд нэгж бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг 106,276 төг/гр байна.

15. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 8,570.30 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 4,205.25 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 68%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1.5 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-2-ын захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөл захиалагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/205 тоот тушаалаар баталсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын дагуу үйл ажиллагаа явуулахыг анхааруулж байна.
2. Төсөл хэрэгжүүлэгч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын дагуу ашиглалтын үйл ажиллагааг явуулж, олборлосон алтаа Монгол улсын төв банк Монголбанкинд “Ирмүүн босго” ХХК-ийн нэр дээр тушааж байхыг анхааруулж байна.
3. Төсөл захиалагчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийхийг үүрэг болгож байна.
4. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол Улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.
5. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг ЭБМЗ-өөс даалгаж байна.

6. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 2-т тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үндэслэлийн тодотгол-2-ыг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Цариг ресурс" ХХК, мөн ТЭЗҮ-ийн тодотгол-2-ын үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын зөвлөх инженер Г.Тамир, Ж.Амгалан нар тус тус хариуцна.

Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-2-т хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. "Төв аймгийн Заамар сумын нутагт MV-019638 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бумбат-6 талбайд орших "Шинээгийн ам" (хш-02-с хш-14), "Жалга-3" (хш-02-с хш-8) алтны шороон ордуудыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 2"-ыг хүлээн авах;
2. Энэхүү дүгнэлтээр хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол-2-ын дагуу ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож, хяналт тавьж ажиллахыг холбогдох хэлтэст даалгах;
3. Төв аймгийн Заамар сумын нутагт MV-019638 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бумбат-6 талбайд орших "Шинээгийн ам" (хш-02-с хш-14), "Жалга-3" (хш-02-с хш-8) алтны шороон ордуудыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол 2, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МОНХЗОРИГ

**“Ирмүүнбосго” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт MV-019638 тоот ашиг  
“Жалга-3” (хш-02-с хш-8) алтны шороон ордуудыг ил аргаар ашиглах техник**

| Блокийн дугаар                  | Геологийн нөөц                     |                          |                  |                                             |                                     |                                   |                   |                         | Ил уурхайн өртөг                   |                          |                  |                                             |
|---------------------------------|------------------------------------|--------------------------|------------------|---------------------------------------------|-------------------------------------|-----------------------------------|-------------------|-------------------------|------------------------------------|--------------------------|------------------|---------------------------------------------|
|                                 | Блокийн талбай, мян.м <sup>2</sup> | Хучаас хөрсний зузаан, м | Элсний зузаан, м | Хучаас хөрсний эзлэхүүн, мян.м <sup>3</sup> | Элсний эзлэхүүн, мян.м <sup>3</sup> | Дундаж агуулга, мг/м <sup>3</sup> | Металл /Шлих/, кг | Металл /Хими цэвэр/, кг | Блокийн талбай, мян.м <sup>2</sup> | Хучаас хөрсний зузаан, м | Элсний зузаан, м | Хучаас хөрсний эзлэхүүн, мян.м <sup>3</sup> |
| <b>Шинээгийн ам /Сорьц-851/</b> |                                    |                          |                  |                                             |                                     |                                   |                   |                         |                                    |                          |                  |                                             |
| C-1                             | 3.12                               | 36.7                     | 1.6              | 114.50                                      | 4.99                                | 1,040                             | 5.19              | 4.42                    | 3.12                               | 36.7                     | 1.6              | 114.50                                      |
| C-2                             | 11.78                              | 36.2                     | 1.6              | 426.44                                      | 18.85                               | 1,012                             | 19.07             | 16.23                   | 11.78                              | 36.2                     | 1.6              | 426.44                                      |
| C-3                             | 14.53                              | 36.1                     | 1.6              | 524.53                                      | 23.25                               | 1,230                             | 28.60             | 24.3                    | 14.53                              | 36.1                     | 1.6              | 524.53                                      |
| C-4                             | 9.41                               | 36.1                     | 1.9              | 339.70                                      | 17.88                               | 1,744                             | 31.18             | 26.54                   | 9.41                               | 36.1                     | 1.9              | 339.70                                      |
| C-5                             | 6.53                               | 34.3                     | 1.4              | 223.98                                      | 9.14                                | 1,669                             | 15.26             | 12.98                   | 6.53                               | 34.3                     | 1.4              | 223.98                                      |
| C-6                             | 9.24                               | 30.5                     | 0.9              | 281.82                                      | 8.32                                | 3,310                             | 27.53             | 23.42                   | 9.24                               | 30.5                     | 0.9              | 281.82                                      |
| C-7                             | 4.10                               | 29.6                     | 1.0              | 121.36                                      | 4.10                                | 3,999                             | 16.40             | 13.95                   | 4.10                               | 29.6                     | 1.0              | 121.36                                      |
| <b>НИЙТ (C)</b>                 | <b>58.71</b>                       | <b>34.6</b>              | <b>1.5</b>       | <b>2,032.33</b>                             | <b>86.53</b>                        | <b>1,655</b>                      | <b>143.22</b>     | <b>121.88</b>           | <b>58.71</b>                       | <b>34.6</b>              | <b>1.5</b>       | <b>2,032.33</b>                             |
| <b>Жалга-3 /Сорьц-913/</b>      |                                    |                          |                  |                                             |                                     |                                   |                   |                         |                                    |                          |                  |                                             |
| C-1                             | 0.42                               | 9.0                      | 0.9              | 3.78                                        | 0.38                                | 519                               | 0.20              | 0.18                    | 0.42                               | 9.0                      | 0.9              | 3.78                                        |
| <b>Нийт C</b>                   | <b>0.42</b>                        | <b>9.0</b>               | <b>0.9</b>       | <b>3.78</b>                                 | <b>0.38</b>                         | <b>519</b>                        | <b>0.20</b>       | <b>0.18</b>             | <b>0.42</b>                        | <b>9.0</b>               | <b>0.9</b>       | <b>3.78</b>                                 |
| B-2                             | 0.78                               | 9.3                      | 0.7              | 7.25                                        | 0.55                                | 472                               | 0.3               | 0.2                     | 0.78                               | 9.3                      | 0.7              | 7.25                                        |
| B-3                             | 1.93                               | 7.6                      | 0.5              | 14.67                                       | 0.97                                | 382                               | 0.37              | 0.3                     | 1.93                               | 7.6                      | 0.5              | 14.67                                       |
| B-4                             | 3.08                               | 11.3                     | 0.6              | 34.80                                       | 1.85                                | 401                               | 0.74              | 0.7                     | 3.08                               | 11.3                     | 0.6              | 34.80                                       |
| B-5                             | 2.99                               | 19.8                     | 0.6              | 59.20                                       | 1.79                                | 578                               | 1.04              | 0.9                     | 2.99                               | 19.8                     | 0.6              | 59.20                                       |
| B-6                             | 1.50                               | 21.5                     | 1.1              | 32.25                                       | 1.65                                | 786                               | 1.30              | 1.2                     | 1.50                               | 21.5                     | 1.1              | 32.25                                       |
| B-7                             | 1.93                               | 17.8                     | 1.1              | 34.35                                       | 2.12                                | 885                               | 1.88              | 1.7                     | 1.93                               | 17.8                     | 1.1              | 34.35                                       |
| B-8                             | 2.50                               | 11.7                     | 0.7              | 29.25                                       | 1.75                                | 1,283                             | 2.25              | 2.0                     | 2.50                               | 11.7                     | 0.7              | 29.25                                       |
| B-9                             | 2.00                               | 10.4                     | 0.5              | 20.80                                       | 1.00                                | 1,793                             | 1.79              | 1.6                     | 2.00                               | 10.4                     | 0.5              | 20.80                                       |
| <b>Нийт B</b>                   | <b>16.71</b>                       | <b>13.92</b>             | <b>0.70</b>      | <b>232.58</b>                               | <b>11.68</b>                        | <b>824</b>                        | <b>9.62</b>       | <b>8.78</b>             | <b>16.71</b>                       | <b>13.9</b>              | <b>0.7</b>       | <b>232.58</b>                               |
| <b>НИЙТ (B+C)</b>               | <b>17.13</b>                       | <b>13.8</b>              | <b>0.7</b>       | <b>236.36</b>                               | <b>12.05</b>                        | <b>814</b>                        | <b>9.81</b>       | <b>8.96</b>             | <b>17.13</b>                       | <b>13.8</b>              | <b>0.7</b>       | <b>236.36</b>                               |
| Ордын хэмжээнд C                | 59.1                               | 34.4                     | 1.5              | 2,036.1                                     | 86.9                                | 1,650                             | 143.4             | 122.1                   | 59.1                               | 34.4                     | 1.5              | 2,036.1                                     |
| Ордын хэмжээнд (B+C)            | 75.84                              | 29.91                    | 1.30             | 2,268.68                                    | 98.58                               | 1,552                             | 153.06            | 130.85                  | 75.84                              | 29.9                     | 1.3              | 2,268.7                                     |

2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХХ-04-11 тоот ЭБМЗ-ийн дүгнэлт, 2022 бүлгийн ордод хамаарч байгаа ба хайгуулын ажлаар тогтоогдсон Геологийн бодитой (боловсруулсан бөгөөд уурхайн хил хязгаар дотор орших бохирдол тооцсон эдийн засгийн өдрийн 203 дугаар тушаалаар баталсан Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадласан В' үйлдвэрлэлийн нөөц нь 130.14 мян.м<sup>3</sup> элс

Бумбат-6 талбайд орших “Шинээгийн ам” (хш-02-с хш-14), “Жалга-3” (хш-02-с хш-8) орших хучаас хөрсөнд 0.2 м зузаан үе үлдээх, ул чулуулгаас мөн 0.2 м зузаан үеийг элсст бөгөөд эдгээр үеүд бохирдуулагч чулуулаг болно. Иймээс ордыг ашиглалтын үед хаягдал

**Үзүүлэлт гаргасан:**

“Цариг Ресурс” ХХК-ийн  
Уулын инженер: .....

 / П.Насанжаргал

ашиглалтын тусгай зөвшөөрлийн Бумбат-6 талбайд орших "Шинээгийн ам" (хш-02-с хш-14),  
 өдрийн засгийн үндэслэлийн тодотгол-2-ын үйлдвэрлэлийн нөөцийн нэгдсэн хүснэгт

| Ашиглалтын нөөц         |                       |                   |                        | Бохирдолт           |                               |                |                                           | Үйлдвэрлэлийн нөөц       |                         |                       |                   |                        |
|-------------------------|-----------------------|-------------------|------------------------|---------------------|-------------------------------|----------------|-------------------------------------------|--------------------------|-------------------------|-----------------------|-------------------|------------------------|
| Элсний эзлэхүүн, мян.м³ | Дундаж агуулга, мг/м³ | Металл /Шлих/, кг | Металл /Хими цэвр/, кг | Бохирдолтын хувь, % | Бохирдуулагч чулуулаг, мян.м³ | Блокийн дугаар | Бортоор нэмэгдэх хөрсний эзлэхүүн, мян.м³ | Хөрсний эзлэхүүн, мян.м³ | Элсний эзлэхүүн, мян.м³ | Дундаж агуулга, мг/м³ | Металл /Шлих/, кг | Металл /Хими цэвр/, кг |
| 4.99                    | 1,040                 | 5.19              | 4.42                   | 27.7                | 1.38                          | B'-1           | 103.5                                     | 217.3                    | 6.4                     | 810.94                | 5.19              | 4.42                   |
| 18.85                   | 1,012                 | 19.07             | 16.23                  | 25.3                | 4.77                          | B'-2           | 134.2                                     | 558.3                    | 23.6                    | 808.05                | 19.07             | 16.23                  |
| 23.25                   | 1,230                 | 28.60             | 24.33                  | 25.8                | 6.0                           | B'-3           | 146.8                                     | 668.4                    | 29.2                    | 979.45                | 28.60             | 24.33                  |
| 17.88                   | 1,744                 | 31.18             | 26.54                  | 22.2                | 4.0                           | B'-4           | 144.1                                     | 482.0                    | 21.8                    | 1,430.28              | 31.18             | 26.54                  |
| 9.14                    | 1,669                 | 15.26             | 12.98                  | 31.5                | 2.9                           | B'-5           | 145.7                                     | 368.4                    | 12.0                    | 1,271.67              | 15.26             | 12.98                  |
| 8.32                    | 3,310                 | 27.53             | 23.42                  | 45.9                | 3.8                           | B'-6           | 130.2                                     | 410.2                    | 12.1                    | 2,275.21              | 27.53             | 23.42                  |
| 4.10                    | 3,999                 | 16.40             | 13.95                  | 42.0                | 1.7                           | B'-7           | 87.3                                      | 207.8                    | 5.8                     | 2,827.59              | 16.40             | 13.95                  |
| 86.53                   | 1,655                 | 143.22            | 121.88                 | 28.4                | 24.5                          | B'             | 891.8                                     | 2,912.4                  | 111.1                   | 1,289.11              | 143.22            | 121.88                 |
| 0.38                    | 519                   | 0.20              | 0.18                   | 47.3                | 0.2                           | B'-1           | 1.8                                       | 5.5                      | 0.6                     | 333.33                | 0.20              | 0.18                   |
| 0.38                    | 519                   | 0.20              | 0.18                   | 47.3                | 0.2                           | B'             | 1.8                                       | 5.5                      | 0.6                     | 333.33                | 0.20              | 0.18                   |
| 0.55                    | 472                   | 0.26              | 0.24                   | 60.1                | 0.3                           | B'-2           | 5.6                                       | 12.7                     | 0.9                     | 288.89                | 0.26              | 0.24                   |
| 0.97                    | 382                   | 0.37              | 0.34                   | 80.8                | 0.8                           | B'-3           | 3.1                                       | 17.4                     | 1.7                     | 217.65                | 0.37              | 0.34                   |
| 1.85                    | 401                   | 0.74              | 0.68                   | 67.8                | 1.3                           | B'-4           | 10.4                                      | 44.5                     | 3.1                     | 238.71                | 0.74              | 0.68                   |
| 1.79                    | 578                   | 1.04              | 0.95                   | 67.9                | 1.2                           | B'-5           | 34.6                                      | 93.2                     | 3.0                     | 346.67                | 1.04              | 0.95                   |
| 1.65                    | 786                   | 1.30              | 1.18                   | 37.3                | 0.6                           | B'-6           | 23.5                                      | 55.4                     | 2.3                     | 565.22                | 1.30              | 1.18                   |
| 2.12                    | 885                   | 1.88              | 1.72                   | 38.3                | 0.8                           | B'-7           | 22.6                                      | 56.6                     | 2.9                     | 648.28                | 1.88              | 1.72                   |
| 1.75                    | 1,283                 | 2.25              | 2.05                   | 58.3                | 1.0                           | B'-8           | 10.9                                      | 39.6                     | 2.8                     | 803.57                | 2.25              | 2.05                   |
| 1.00                    | 1,793                 | 1.79              | 1.64                   | 81.3                | 0.8                           | B'-9           | 8.5                                       | 28.9                     | 1.8                     | 994.44                | 1.79              | 1.64                   |
| 11.68                   | 824                   | 9.62              | 8.78                   | 58.6                | 6.8                           | B'             | 119.1                                     | 348.3                    | 18.5                    | 520.00                | 9.62              | 8.78                   |
| 12.05                   | 814                   | 9.81              | 8.96                   | 58.2                | 7.0                           | B'             | 120.9                                     | 353.8                    | 19.1                    | 513.61                | 9.81              | 8.96                   |
| 86.9                    | 1,650                 | 143.4             | 122.1                  | 28.4                | 24.7                          | B'             | 893.6                                     | 2,917.9                  | 111.6                   | 1,284.95              | 143.4             | 122.1                  |
| 98.58                   | 1,552                 | 153.06            | 130.85                 | 32.0                | 31.56                         | B'             | 1,012.70                                  | 3,266.23                 | 130.14                  | 1,176.12              | 153.06            | 130.85                 |

оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Н-39 тоот тушаалаар батлагдсан нөөцийн дүгнэлтэд орд нь III (B) болон боломжтой (C) зэрэглэлийн нөөцөд тулгуурлан ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотгол-2-ыг хувьд үр ашигтай үйлдвэрлэлийн нөөцийг Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний захираа, зааврын дагуу бодитой B болон боломжтой C зэрэглэлийн нөөцийг магадласан (B') үйлдвэрлэлийн буюу хими цэврээр 130.85 кг алт болж байна. /Шлихээр 153.06 кг/.

-8) алтны шороон ордуудад хаягдалгүй ашиглалт явуулахын тулд алттай элсний давхаргаас дээш цуг олборлолтонд хамруулахаар тооцсон. Мөн уурхайн хажуугаас элсийг бохирдуулахаар тооцсон үй олборлоно.

## Танилцсан:

АМГТГ-ын ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, бүртгэл хариуцсан мэргэжилтэн: ..... /Ц.Золзаяа /

дүгнэлт өгсөн  
 20/6  
 2022



“ИРМҮҮН БОСГО” ХХК-Д

**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,  
Цахим шуудан: [contact@met.gov.mn](mailto:contact@met.gov.mn),  
Цахим хуудас: [www.met.gov.mn](http://www.met.gov.mn)

2022.08.23 № 13/4667  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт  
хүргүүлэх тухай**

Танай компаниас боловсруулан ирүүлсэн Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй Бумбат-6 /MV-019638/ тоот тусгай зөвшөөрөл бүхий “Алтны шороон орд”-ны төсөлд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Засгийн газрын 2013 оны “Журам батлах тухай” 374 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.


Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулан 2023 оны 2 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт... хуудастай

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Г.ЭНХМӨНХ

**ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСЭЛТ, БАРИМТ БИЧИГ  
ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ**

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:** "Ирмүүн босго" ХХК, /Регистрийн дугаар: 5396786/, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, 1 хороолол, 13А-31 тоот

**Холбоо барих утас, И-мэйл хаяг:** 976-99121717, 11-633875

**Төслийн нэр:** "Алтны шороон орд"

**Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:** Төв аймгийн Заамар сум

| Баримт бичгийн нэр                                                                                                                                                                                                                                    | Шаардлагатай эсэх | Шаардлага хангасан эсэх | Тайлбар                                                      |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|-------------------------|--------------------------------------------------------------|
| Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/                                                                                                                                                                              | Тийм              | +                       | 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 43 дугаар албан бичиг |
| Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөл                                                                                                                                                                                             | Тийм              | +                       |                                                              |
| Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан эсэх /газрын зөвшөөрөл, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал/                                                                                                    | Тийм              | +                       |                                                              |
| Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт                                                                                                                                                                              | Үгүй              | -                       |                                                              |
| Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан                                                                                                                                                                         | Тийм              | +                       | "Эко экспресс" ХХК-д боловсруулсан.                          |
| Төсөл хэрэгжих орчны тойм зураг (топо, сансрын)                                                                                                                                                                                                       | Тийм              | +                       |                                                              |
| Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт                                                                                                                                                                                                        | Тийм              | +                       |                                                              |
| Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/                                                                                                                                                                                   | Тийм              | +                       |                                                              |
| <b>Тусгай тэмдэглэл:</b><br>"Алтны шороон орд"-ны төсөлд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын "Аргачлал батлах тухай" 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэх шаардлагатай гэж үзлээ. |                   |                         |                                                              |

**Ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт, материалыг хянасан:**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ЯАМНЫ ШИНЖЭЭЧ**

  
**Н.ЭРДЭНЭЧИМЭГ**

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ХУУДАС

2022 оны 08-р сарын 18

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2022/Е86

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:** "Ирмүүн босго" ХХК, /РД:5396786/, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, 1 хороолол, 13А-31 тоот

**Холбоо барих утас, И-мэйл хаяг:** 976-99121717, 11-633875

**Төслийн нэр:** "Алтны шороон орд"

**Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:** Төв аймгийн Заамар сум

**Орон нутгийн санал:** Төв аймгийн Заамар сумын Засаг Даргын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 1/240 тоот санал, Е-Монголиа О99-2207-000033 дугаар хүсэлтийг тус тус үндэслэв.

|                                                   | Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд                                                                                                                                                         | Нийцсэн | Нийцээгүй | Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай | Үндэслэл, тайлбар                                                               |
|---------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|-----------|----------------------------------------|---------------------------------------------------------------------------------|
